

НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ САХИУЛАХ НЬ ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН СУУРЬ НӨХЦӨЛ БОЛОХ НЬ

MAINTAINING PUBLIC ORDER IS THE FUNDAMENTAL CONDITIONS FOR PROVIDING COMMUNITY SAFETY



Б.БАЯНМӨНХ

Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, цагдаагийн хошууч

BAYANMUNKH B.

Assistant professor of Police administrative department, Police school of Law Enforcement university, Police major

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд 2 үндсэн асуудлын талаар дурдсан болно. Тухайлбал, а.Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндсэн эх сурвалж нь нийгмийн дэг журам, нийгмийн хэв журам, нийтийн хэв журам гэсэн 3 үндсэн ухагдахуун дээр тодорхойлогдож байгаа талаар, б.Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндсэн суурь нөхцөл нь нийтийн хэв журам сахиулах үйл ажиллагаа юм гэдгийг цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны арга, хэлбэрт үнэлэлт, дүгнэлт өгсөн тухай дурдсан болно.

Abstract: This article attempts to examine the following two issues of Mongolian police. First, regarding the fundamental concepts of police actions of public security engagement based on such resources as social discipline, public order and community security. Second, this paper evaluates and analyses police actions of maintaining public order which is enhanced through creating fundamental conditions for community safety.

Түлхүүр үгс: Нийгмийн дэг журам, нийгмийн хэв журам, нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдал.

Key words: Public order, social order, public/community safety

Манай зарим хуульч эрдэмтэн судлаачид цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны чиг хандлагыг янз бүрээр тодорхойлж, тэр хэмжээгээрээ цаашдын хөгжлийг томъёолохыг оролддог.

Энэ нь цагдаагийн байгууллагын цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, үйл ажиллагааг зөв гольдрилд оруулахад чухал хүчин зүйл болдог байна.

Гэхдээ үүнд цагдаагийн байгууллагын үе үеийн удирдлагуудын баримталж ирсэн бодлого ихээхэн чухал нөлөө

үзүүлж ирснийг мартаж болохгүй юм. Тухайлбал, цагдаагийн байгууллагын зарим удирдлага гэмт хэргийн илрүүлэлтийг тэргүүлэх чиглэлээ болгодог байсан бол, зарим удирдлага урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэлээ болгодог байснаар харж болно.

Гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн арга бол урьдчилан сэргийлэх ажлыг чанартай зохион байгуулах явдал юм. Өнөөдөр гэмт хэргийг гарсан хойно нь хөрөнгө мөнгө, хүч хэрэгсэл зарцуулан байж

илрүүлэх, шийдвэрлэхдээ биш, харин гарахаас нь өмнө аль болох урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, эрх зүйн зөрчил гарах нөхцөл байдлуудыг арилгахад чиглэгдсэн арга хэмжээг иж бүрэн цогцолбороор нь явуулах нь чухал байна.

Гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил хаана хангалтгүй зохион байгуулж, ач холбогдол өгөхгүй байна, тэнд гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгдэх болно гэдгийг бүгд мэддэг боловч үүнд төдийлөн ач холбогдол өгдөггүй, нөгөө талаараа урьдчилан сэргийлэх ажлыг хэлбэрийн төдий явуулсаар байна.

Нөгөө талаараа урьдчилан сэргийлэх ажлын үр дүн муутай зарим аргуудыг өнөөг хүртэл хэрэгжүүлсээр байгаа нь энэ бүх ажилд шинжлэх ухааны үндэслэл бүхий үнэлэлт, дүгнэлт өгөхгүй, хуучны хэвшмэл хандлагаасаа салахгүй байгаатай салшгүй холбоотой юм.

Гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх ажлын нэг үндсэн хэлбэр бол нийтийн хэв журам сахиулах үйл ажиллагаа билээ.


Тэгвэл өнөөдөр нийтийн хэв журам сахиулах үйл ажиллагааны үндсэн объект болсон нийтийн хэв журмын талаарх нэр томъёоны тодорхойлолтыг манай эрдэмтэн, судлаачид өөр өөрсдийнхөөрөө тодорхойлсон боловч нийтийн хэв журам нь чухам юунаас эхтэй болох, уялдаа холбооны талаар тусгайлан судалсан зүйл харьцангуй бага байна.

Монгол Улсын Үндсэн хуульд “нийгмийн хэв журам”, “нийгмийн дэг журам” гэсэн нэр томъёо орсон бөгөөд нийгмийн дэг журам гэсэн ойлголтыг тайлбарласан тайлбар өнөөг хүртэл байхгүй байна.

Харин “нийгмийн дэг журам”-ыг “эрх зүйн дэг журам” гэсэн ойлголтод хамруулан авч үзэж болох юм.

Онолын үүднээс дээрх нэр томъёонуудын хууль тогтоомжид тусгагдсан байдал, зохицуулж байгаа харилцааны хамрах хүрээ, агуулгын эх

сурвалжаас нь хамааруулан авч үзээд хоорондын уялдаа холбоог дараах байдлаар тодорхойлж болохоор байна. Тухайлбал:



Нийгмийн дэг журам гэсэн нэр томъёоны бүрэлдэхүүн хэсэгт нийгмийн хэв журам нь багтах бөгөөд бид эхлээд эрх зүйн дэг журам гэсэн ойлголтын талаар авч үзэх шаардлагатай юм.

Нийгмийн дэг журмын тухай доктор Ц.Наранчимэг өөрийн бүтээлдээ дараах агуулгаар тайлбарласан байна. Тэрээр “Хүн бол нийгмийн амьтан билээ. Нийгэмд амьдрах хувь тавилан хүнийг хүссэн ч, эс хүссэн ч ялгаагүй, бусадтай хамтран аж төрөхөөс өөрөөр байх боломжгүй, тийм нэг гарцаагүй байдалд хүргэдэг байна.

Хүн тийнхүү нийгэмд амьдрахдаа зөвхөн өөрийн зоргоор авирлаж, дур хүслээр үйлдэж эхэлбэл сөргөлдөн зөрчилдөж, цаашдаа хамтдаа байх боломжгүй болно. Тийм учраас үйлдэж болох хийгээд болохгүйн хэмжүүр тогтоож, хүмүүний үйлийг хянах хэрэгцээ гарах ажээ. Үүнийг нийгмийн дэг журам хэмээн нэрлэсээр нэгэнт заншсан байх ажаам” хэмээсэн нь хамгийн энгийн, ойлгомжтой байдлаар тайлбарласан тайлбар гэж үзэж болно.

Нийгмийн дэг журам хаана сайн байна, тэнд амьдрал амгалан тайван, хүмүүс эв нэгдэлтэй, амар жимэр аж төрөн суух нь зүй ёсны хэрэг билээ.

Мөн тэрээр “Мөнөөх нийгмийн дэг журмын нэг хэсгийг хамтдаа аж төрж буй нийгмийн бусад гишүүдийн зүгээс тулган хүлээлгэхийг оролдох, нэг хэсгийг төрөөс шаардан засаглах, бас нэг хэсгийг өөрөө өөртөө хэмжүүр болгон хэрэглэх эл гурван чигтэй мэт



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ САХИУЛАХ
УНДСЭН ХУУЛЬ

санагдана” гэж тусгасан нь нийгмийн дэг журам гэх ойлголтыг тодорхойлохыг оролдсон гэж харж болно.

Нийгмийн бүхий л харилцааг зохицуулсан хэм хэмжээ бол нийгмийн хэм хэмжээ билээ. Нийгмийн хэм хэмжээ нь нийгмийн хөгжлийн явцад хүмүүсийн ухамсар, хүсэл зоригийн дагуу бий болж, нийгмийн зүгээс хамгаалагдаж, хангагдаж байдаг нийгмийн гишүүдээс удирдлага болговол зохих зан үйлийн горимын тогтолцоо юм.

Харин эрх зүйн дэг журам бол нийгмийн гишүүдээс удирдлага болговол зохих зан үйлийн горимын тогтолцоог зохицуулж байгаа хэм хэмжээний хэрэгжилтийн эцсийн үр дүн юм.

Эрх зүйн дэг журам нь хууль ёс, эрх зүйн үндсэн дээр журамлагдсан нийгмийн харилцааны бодит байдлын илрэл юм.

Доктор Ч.Нямсүрэн “Эрх зүйн дэг журам нь нийгмийн хэв журмын хүрээнд оршиж, эрх зүйн хэм хэмжээгээр тогтоогдож, эрх зүйн хэрэгжилт, түүний үр дүнгээр тодорхойлогдож байгаа эрх зүйн харилцааны бодит байдал мөн” хэмээн тодорхойлсон байна.

Эрх зүйн дэг журмыг агуулгын бүтцээс нь авч үзвэл эрх гэдэг нь нийгэм дэх хүмүүсийн харилцааг зохицуулан төр засгаас тогтоон хамгаалах хэм хэмжээний цогц, зүй гэдэг нь аливаа юмны тогтоол жам ёс ба түүнд тавтайяа нийлэлцэх зүй тогтол, “дэг” гэдэг нь горим журам, “журам” – хууль зүй, хэв суртлыг дагаж тогтсон ёс зарчим хэмээн задлан авч үзэж болох юм.

Нийгмийн дэг журмын нэг бүрэлдэхүүн хэсэгт нийгмийн хэв журам байх ба нийгмийн хэв журмын бүрэлдэхүүн хэсэг дотор нь нийтийн хэв журам байна.

Доктор, профессор Ж.Долгорсүрэн нийгмийн хэв журмыг өргөн болон явцуу утгаар нь тодорхойлж, нийгмийн хэв журам, олон нийтийн хэв журам гэж хоёр зааглан авч үзсэн байна. Тэрээр “Нийгмийн хэв журам гэдэг нь өргөн

утгаараа хүмүүсийн хоорондын харилцах явцад хүн амын амгалан тайван байдал, иргэдийн ая тухтай амрах, хөдөлмөрлөх бололцоог хангах, нийтийн захиргаа, төрийн ба төрийн бус байгууллагын хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой иргэний нийгмийн хэрэгцээт шаардлагатай нөхцөлдөн гарсан, Монголын ард түмний эрх ашигт нийцэх зан заншил, уламжлал, ёс суртахуун, эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж буй харилцааны бүхэллэг тогтолцоо мөн” гэсэн байна.

Мөн тэрээр олон нийтийн хэв журмыг “зөвхөн олон нийтийн газар хүмүүсийн хоорондоо харилцах явцад бүрэлдэн тогтсон нийгмийн харилцааны нэг хэсэг тогтолцоо” гэж тодорхойлсон байна.

Мөн доктор Г.Совд “Хүн амын аж төрөн амьдрах, ажил, хөдөлмөр эрхлэх амарч, цэнгэх аливаа ёс заншил, ёслон тэмдэглэх бүх нийтээр хүлээн зөвшөөрч хэвшсэн буюу хуулиар тогтоосон нийгмийн хэм хэмжээний нийлбэр цогц”, доктор Ч.Нямсүрэн “Нийгмийн хэв журам гэдэг нь иргэдээс олон нийтийн газар болон ахуйн орчинд олон нийтийн сахилгыг сахих, иргэдийн эрх, эрх чөлөө, зан суртахуун ба нийгмийн амгалан тайван байдлыг хангах хамгаалалт мөн”, судлаач Б.Сутай “Нийгмийн хэв журам гэдэг нь иргэд, олон нийтийн газар, ахуйн орчин зэрэг олон нийт хүмүүсийн хоорондын харилцаанд оролцох явцдаа, иргэдийн эрх, ашиг сонирхлыг хүндэтгэн амгалан тайван байдал, ая тухтай нөхцөл, хөдөлмөрлөх бололцоог хангах зорилготой эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж буй нийгмийн бүхэл харилцааны тогтолцоо юм” хэмээн тус тус тодорхойлжээ.

Нийгмийн хэв журмыг агуулгын бүтэц талаас нь авч үзвэл нийгэм - нийгэмлэг, нийгэм журам (эв хамтын нийгмийн, нийгэм-эдийн засгийн давхаргын анхны үе, нийгэм журмын бүтээн байгуулалт), хэв III - дадаж заншсан уламжлалт ёс журам, журам – хууль зүй, хэв суртлыг дагаж тогтсон ёс зарчим гэж задалж үзэж болно.



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ САХИУЛАХ
УНДСЭН ХУУЛИЙН
УНДСЭН ХУУЛИЙН
УНДСЭН ХУУЛИЙН

Харин нийтийн хэв журмыг “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”-д “нийгмийн амгалан тайван байдал, хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж буй нийгэмд тогтсон хүмүүсийн хоорондын харилцааны болон аж төрөх ёсны хэм хэмжээ” хэмээн тодорхойлсон байна.

“Нийтийн дэг журам”, “Нийгмийн хэв журам”, “Нийтийн хэв журам” гэсэн 3 нэр томьёог хуульд тусгасан байдал болон хэрэгжүүлэх субъект, гүйцэтгэх үүргийн онцлогоос нь хамаарч хоорондын уялдаа холбоог нь дараах байдлаар тодорхойлж болохоор байна.



Нийгмийн хэв журмыг бэхжүүлэх үүргийг Засгийн газар хүлээдэг бол энэхүү нийгмийн хэв журмын нэгж бүрдэл хэсэг болсон нийтийн хэв журам хамгаалах үүргийг цагдаагийн байгууллага хүлээнэ.

Харин иргэд олон нийт нийгмийн хэв журам, нийтийн хэв журам гэсэн 2 ойлголтыг хараахан салгаж ойлгохгүй байх шиг байна.

1993 онд “Цагдаагийн байгууллагын тухай хууль” батлагдаж, Цагдаагийн байгууллага өөрийн гэсэн хуультай болсон бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах гэсэн чиг үүргийг хэрэгжүүлсээр даруй 20 гаран жил өнгөрсөн байна. Харин 2013 онд “Цагдаагийн албаны тухай хууль” шинэчлэгдэн батлагдан гарсан бөгөөд уг хуулиар цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам

хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах гэсэн чиг үүргийг хэрэгжүүлэхээр болсон.

Одоогоос 22 жилийн өмнө тухайн үеийн Цагдаагийн Ерөнхий газрын даргаар ажиллаж байсан, хошууч генерал Б.Пүрэв цагдаагийн байгууллагын гүйцэтгэх үүргийн нэг болох нийгмийн хэв журам гэсэн нэр томьёог нийтийн хэв журам гэж өөрчлөх талаар санал оруулж байсан боловч тухайн үеийн Улсын Их Хурал асуудлыг шийдвэрлэж өгөөгүй байна.

Тэрээр УИХ-ын чуулган дээр “Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 7-д Засгийн газар нийгмийн хэв журам бэхжүүлэх үүрэгтэй гэж заасан. Энэ бол Засгийн газрын үүрэг. Цагдаа бол энэ нийгмийн

хэв журам дотроос олон нийтийн хэв журмыг нь хариуцсан байгууллага юм. Засгийн газрын үүргийг биелүүлэхийн тулд түүний бүтцэд багтдаг 20 яам, газар цөм оролцох ёстой. Цагдаа 20 байгууллагын нэг нь учир өөртөө ногдох хувиа л хариуцна. Ариун цэврийн, тээвэр ашиглалтын, байгаль орчныг хамгаалах, боловсрол, соёл гээд цагдаа зохицуулж чадахгүй хэв журам зөндөө бий шүү дээ” гэж хэлж байсан боловч гишүүд хүлээж аваагүй байна.

Цагдаагийн албаны тухай хуулиар цагдаагийн байгууллагад хүлээлгэсэн нэг шинэ үүрэг бол олон нийтийн аюулгүй байдлыг хангах гэсэн үүрэг билээ.

Доктор, профессор Ж.Долгорсүрэн “Нийтийн аюулгүй байдал гэдэг нь

¹ Б.Пүрэв. Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн тайлбар. УБ., 1997. 14 дэх тал.



байгалийн гамшиг, нийтэд хамааралтай бус аюул, осол болон зарим байгууллага, хүмүүс хүрээлэн байгаа орчиндоо эд зүйл, механизмтай зүй бус харьцсанаас хүний амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгөнд учирч болох хор хөнөөлийг арилгах, таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх зорилготой, иргэний нийгмийн бүтээн байгуулалтын хэрэгцээт шаардлагаар нөхцөлдөн гарсан, Монголын ард түмний ашиг сонирхолд нийцсэн эрх зүй, зохион байгуулалт-техникийн хэм хэмжээ, горимоор зохицуулагдаж байгаа нийгмийн харилцааны тогтолцоо² гэж тодорхойлсон бол ЦЕГ-ын даргын баталсан “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”-д “Олон нийтийн аюулгүй байдал” - байгалийн гамшиг, гэнэтийн осол болон байгууллага, хүмүүсээс хүрээлэн байгаа орчин, эд зүйл, механизмтай зүй бус харьцсанаас хүний амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгөнд учирч болох хор хөнөөлийг арилгах, таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн эрх зүй, зохион байгуулалт, техникийн хэм хэмжээ³ хэмээн тусгасан байна.

Гэвч олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь нийтийн хэв журам сахиулах үйл ажиллагааны нэг бүрэлдэхүүн хэсэг болох тал дээр судлаачид өөр өөр байр суурьтай байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлд олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хамаарах үүргүүдийг тусгайлан оруулж өгсөн. Гэвч эдгээр олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргүүдийг хэрэгжүүлэхдээ хэв журам сахиулах ажиллагаануудыг ихэвчлэн явуулж байгаагаас харж болох юм. Тухайлбал:

• Дипломат төлөөлөгчийн газрыг хамгаалахад объектын хамгаалалтын гадна бүсэд хэв журам сахиулах эргүүл, харуулын үүрэг, улсын онц чухал болон

бусад объектыг хамгаалахад объектын дотор болон гадна бүсэд хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон журмын хэм хэмжээг сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох хэв журмын эргүүл, харуулын үүрэг гүйцэтгэх;

• Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн бусад аюул тохиолдсон үед хорио цээрийн дэглэмийг сахиулах, нэвтрэн орох гарах хөдөлгөөнд хяналт тавих, нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон журмын хэрэгжилтэд хяналт тавих, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үүрэг бүхий хэв журмын эргүүл, харуулын үүрэг гүйцэтгэх

• Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан бүсэд нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон журмын хэрэгжилтэд хяналт тавьж, хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох хэв журмын эргүүл, харуулын үүрэг гүйцэтгэх;

• Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль тогтоомжид заасан гадаадын төрийн өндөр хэмжээний зочин төлөөлөгчдийн хамгаалалтын гадна бүсэд хэв журам сахиулах эргүүл, хэв журмын харуулын үүрэг гүйцэтгэх;

• Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу гэрч, хохирогчийг хамгаалах, гэмт халдлагад өртөхөөс урьдчилан сэргийлж, цагдаагийн харуул хамгаалалтад авах, уг хамгаалалтын бүсэд хэв журам сахиулах эргүүл, харуулын үүрэг гүйцэтгэх;

• Нийтийг хамарсан арга хэмжээний үед гэмт хэрэг, хэв журмын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон журмын хэрэгжилтэд хяналт тавих, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үүрэг бүхий хэв журмын эргүүл, хамгаалалтын үүрэг гүйцэтгэх

• Цагдаагийн байгууллага нь эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр жагсаал, цуглааныг албадан тараах ажиллагааг гүйцэтгэхдээ оролцогчдод хэв журам сахих, сайн дураараа тарахыг шаардах, зохион байгуулагчдад

² Ж.Долгорсүрэн. Монгол Улсын Цагдаагийн эрх зүйн курс. УБ., 2014. 39 дэх тал.

³ ЦЕГ-ын даргын 2015 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн а/44 тоот тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”-ын код 500-д тусгасан байна.

мэдэгдэл хүргүүлэх зэрэг гэмт хэрэг, хэв журмын зөрчил үйлдэгдэх, цааш даамжрахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлж буй бүхий хууль сахиулах ажиллагаанууд нь бүгд л хэв журам сахиулах үйл ажиллагаанд хамаардаг.

Энэ бүгдээс харахад олон нийтийн аюулгүй байдлыг хангах бүхий л үйл ажиллагааны үндсэн суурь нь хэв журам сахиулах ажиллагаа болохыг харж болох бөгөөд нийтийн хэв журам сахиулах үйл ажиллагааны арга, хэлбэрийг сайжруулж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах эх үндэс болно.

ДҮГНЭЛТ

Өнөөдөр “олон нийтийн аюулгүй байдал” гэсэн нэр томъёог Монгол Улсын хууль тогтоомж болон эрдэмтэн, судлаачдын ном бүтээлд өөр өөр байдлаар томъёолсон байна.

Эрдэмтэн судлаачдын томъёолсон тодорхойлолт болон эрх зүйн актад дурдагдсан олон нийтийн аюулгүй байдлын тухай нэр томъёоны агуулгыг үндсэн сурвалжтай нь харьцуулан авч үзэхэд нийгмийн дэг журам, нийгмийн хэв журам, нийтийн хэв журам гэсэн 3 нэр томъёоны агуулгын суурь дээр тодорхойлогдож байна.

Нөгөө талаараа цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа арга, хэлбэр, эрх зүйн зохицуулалтын хамрах хүрээ талаас нь харвал олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндсэн суурь нөхцөл нь нийтийн хэв журам хамгаалах үйл ажиллагаа юм гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

САНАЛ

Дээрх дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Эрдэмтэн, судлаачид болон цагдаагийн байгууллагын холбогдох эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтнүүдийг оролцуулсан “Олон нийтийн аюулгүй байдал-нэр томъёоны асуудал” сэдвийн хүрээнд эрдэм шинжилгээний онол, практикийн бага хурал зохион байгуулж, нэр томъёоны нэгдсэн нэг ойлголтод хүрэх;

2. Цагдаа судлал төвийн судлаачдаар Нийтийн хэв журам хамгаалах алба болон Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны алба хаагчдын явуулж буй хууль сахиулах үйл ажиллагааны арга, хэлбэр, эрх зүйн зохицуулалтад харьцуулсан судалгаа хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, давхардсан ажил үүргийг гаргаж ирэх, адилтгах болон ялгамжтай талуудыг тодорхойлох, давхардлыг арилгах чиглэлээр үндэслэл бүхий санал дэвшүүлэх зэрэг болно.

**Уншиж танилцан нийтлэхийг зөвшөөрсөн:
Сэтгүүлийн зөвлөлийн гишүүн, хууль зүйн доктор,
цагдаагийн хурандаа Ю.Бадамханд**



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ САХИУЛАХ
УНДСЭН СУУРЬ